



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/708

Мөрөн сум

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/122 дугаар тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, үнэлгээний дүн, гэрээний талуудад өгөх зөвлөмжийг тухай бүр аймгийн Засаг даргад танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа), гэрээний хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), гэрээнд тусгагдсан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ажлын хэсэг шинэчлэгдсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/344 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

2
Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 31-ний өдрийн А/2024 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Гишүүд:

- Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Эрүүл мэндийн газрын Мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- “Далайн-Элбэрэлт” өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга
- Иргэний төлөөлөл

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний
хэлтсийн дарга

_____оОо_____